- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд уурхайн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

*Хүснэгт 8. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах*

| Байгаль орчны асуудлууд                                                                                                                                 | Нөлөөлөл байхгүй | Гол үр дагавар |      |           |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|----------------|------|-----------|
|                                                                                                                                                         |                  | Муу (бага)     | Дунд | Сайн (их) |
| Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал                                                                                                      |                  |                |      |           |
| Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал                                                                                                         | х                |                |      |           |
| Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх                                                                        | х                |                |      |           |
| Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох                                                                                                    | х                |                |      |           |
| 2. Төслийн шийдэл, төлөвлөөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал                                                                                       |                  |                |      |           |
| Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой              |                  |                |      | х         |
| Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн            |                  |                | х    |           |
| Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан                                                                   |                  |                |      | х         |
| Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх                                                                                     | х                |                |      |           |
| Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх                                                                             |                  | х              |      |           |
| 3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал                                                      |                  |                |      |           |
| Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал                                                                                                    |                  | х              |      |           |
| Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл                                                                                                            |                  |                |      | х         |
| Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл                                                                             |                  |                | х    |           |
| 4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал                                                                                                        |                  |                |      |           |
| Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх                              |                  |                | х    |           |
| Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх                                                               |                  |                | х    |           |
| Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа) |                  |                | х    |           |
| Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)                                                                |                  | х              |      |           |
| 5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)                                                                              |                  |                |      |           |
| Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал                |                  |                |      | х         |

#### *Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл*

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

#### *Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал*

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

### Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтанд хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

### 3.3. Төслийн гол сөрөг нөлөөллийг үнэлэх

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс төсөл хэрэгжих үеийн болон ашиглалтын үе шатанд хөрс, агаар, бэлчээр, газрын доорх ус зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна. Иймд эдгээр нь голлох нөлөөлөлд багтана. Сөрөг нөлөөллийг байгаль орчны үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй авч үзлээ.

#### 2.1.1. Агаарын чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

Уурхайн үйл ажиллагаа жигдрэх үед агаарыг бохирдуулах 2 эх үүсвэр бий болно. Энэ нь нэгт машин техникээс гарах утаа, хоёрт элс хайрга олборлолтоос үүсэх тоос юм. Ил уурхай болон чулуулгийн овоолго хийхэд бульдозер, автомашин зэрэг уул уурхайн техник зэрэг ажиллах нөхцөлд, дотоод шаталтын хөдөлгүүрийн утаа, ажилчдын сууц, гал тогоо зэрэг байгууламжуудын ердийн зуухнаас гарах утаа агаар орчинг бохирдуулна.

Гэхдээ энэ нь агаарын бохирдол багатай дулааны улиралд гарах учир нийслэлийн агаарын бохирдолд ноцтой нөлөө үзүүлэхгүй юм.

Хүснэгт 9. Агаарын чанарт нөлөөлөх байдал

| №       | Нөлөөлөл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Нөлөөллийн эрчим цар хүрээ тохиолдох магадлал | Бага | Дунд | Их |
|---------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------|------|------|----|
| 1       | Хүчтэй салхитай үед уурхайн ухааш, овоолго, зам талбайгаас үүсэх тоос агаарт байх тоосжилтын хэмжээг ихэсгэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Зайлшгүй                                      |      | x    |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Боломжтой                                     |      |      |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Магадлал муу                                  |      |      |    |
| 2       | Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт агаарын чанарын стандартаас хэтрэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Зайлшгүй                                      |      |      |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Боломжтой                                     | x    |      |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Магадлал муу                                  |      |      |    |
| 3       | Тоосжилт ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Зайлшгүй                                      |      | x    |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Боломжтой                                     |      |      |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Магадлал муу                                  |      |      |    |
| 4       | Тоосжилт ургамалд нөлөөлөх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | Зайлшгүй                                      |      |      |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Боломжтой                                     |      | x    |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Магадлал муу                                  |      |      |    |
| 5       | Тээврийн хэрэгсэл болон уулын техник, дизель станцаас хаягдах утаа бүс нутгийн агаарын чанарт сөргөөр нөлөөлөх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Зайлшгүй                                      | x    |      |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Боломжтой                                     |      |      |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Магадлал муу                                  |      |      |    |
| 6       | Ахуйн хог хаягдал тархсанаас эвгүй үнэр гаргах                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Зайлшгүй                                      | x    |      |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Боломжтой                                     |      |      |    |
|         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Магадлал муу                                  |      |      |    |
| Дүгнэлт | Төслөөс орчны агаарын чанарт үзүүлэх 6 боломжит нөлөөллийг тодорхойлсон бөгөөд нөлөөллийн эрчим цар хүрээгээрээ эдгээрийн 3 нь бага 3 нь дунд зэрэглэлд хамаарч байна. Нийт тодорхойлогдсон нөлөөллүүдээс боломжтой гэсэн ангилалд 2, зайлшгүй гэсэн ангилалд 4 нөлөөлөл орж байна. Эндээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн эрчим нь харьцангуй бага байхаар харагдаж байгаа ч үүсэх сөрөг нөлөөллийг магадлалын талаас авч үзвэл зайлшгүй ангилалд дийлэнх нь хамрагдаж байна. Иймд цаашид технологийн шат дамжлага бүрт агаарт босох тоос шороо болон дотоод шаталтад хөдөлгүүр автомашины яндангаас гарах утааг ЗДХ-ээс давуулахгүй байх арга хэмжээг авч ажиллаж байх нь зүйтэй. |                                               |      |      |    |

#### 2.1.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал, үнэлгээ

Төслийн талбай нь Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт А/0004 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд 23 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулна. Ашиглалтын хугацаанд нийт 1.57 га талбай уурхайн олборлолтонд өртөнө.

Хүснэгт 10. Газрын гадарга ба хэвлийд нөлөөлөх байдлын үнэлгээ

| №       | Нөлөөлөл                                                                                                                       | Нөлөөллийн эрчим цар хүрээ<br>Тохиолдох магадлал                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Бага | Дунд | Их |
|---------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|----|
| 1       | Уурхайг ил аргаар ашиглах үед 54.75 га ашигт малтмал олборлох, хөрсний овоолго хийх явцад газрын гадаргуу үндсэндээ өөрчлөгдөх | Зайлшгүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |      |      | х  |
|         |                                                                                                                                | Боломжтой                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |      |      |    |
|         |                                                                                                                                | Магадлал муу                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |      |      |    |
| 2       | Уул уурхайн олборлолтын улмаас эрдэс баялгийн нөөц хомсдох, хоосон орон зай, нүх үлдэх                                         | Зайлшгүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |      |      | х  |
|         |                                                                                                                                | Боломжтой                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |      |      |    |
|         |                                                                                                                                | Магадлал муу                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |      |      |    |
| 3       | Ажилчдын хотхон ба бусад байгууламжийн нөлөөллөөр газрын гадарга өөрчлөгдөх                                                    | Зайлшгүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |      |      |    |
|         |                                                                                                                                | Боломжтой                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |      | х    |    |
|         |                                                                                                                                | Магадлал муу                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |      |      |    |
| 4       | Газрын гадарга ба хэвлий хог хаягдлаар бохирдох                                                                                | Зайлшгүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |      |      |    |
|         |                                                                                                                                | Боломжтой                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |      | х    |    |
|         |                                                                                                                                | Магадлал муу                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |      |      |    |
| 5       | Олон салаа зам гарч газрын гадаргыг элэгдэл эвдрэлд оруулах                                                                    | Зайлшгүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |      |      |    |
|         |                                                                                                                                | Боломжтой                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |      | х    |    |
|         |                                                                                                                                | Магадлал муу                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |      |      |    |
| Дүгнэлт |                                                                                                                                | Төслөөс газрын гадарга ба хэвлийд үзүүлэх 5 боломжит нөлөөллийг тодорхойлсон бөгөөд нөлөөллийн эрчим цар хүрээгээрээ эдгээрийн 2 нь их 3 нь дунд, үлдсэн зэрэглэлд хамаарч байна. Нийт тодорхойлогдсон нөлөөллүүдийн 40% нь зайлшгүй тохиолдох бол боломжтой ба магадлал дунд гэсэн ангилал тус бүр 60% байна. Эндээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга ба хэвлийд үзүүлэх нөлөөлөл нь дундаас их байхаар байна. Нөгөө талаас нөхөн сэргээлтийн ажлыг амжилттай гүйцэтгэсний үр дүнд дээрх нөлөөллийг бууруулах, арилгах бүрэн боломжтой. |      |      |    |

### 2.1.3. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдал, үнэлгээ

Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд уул уурхайн болон аж ахуйн газар бий болсноор үржил шимт хөрсийг хуулах, дагтаршуулах зэргээр хүний үйл ажиллагааны нөлөө удаан хугацаагаар ноёлж байгаагаас тус нутгийн унаган экосистем бүрэн алдагдаж хайрга, элс, шороон хөрс бий болсон байна.

Уурхайн ойр орчмын хөрс нь авто машины болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртөнө. Хуурай хог хаягдлаар орчин бохирдох, хөрсний бохирдол үүсэх зэргээр нөлөөлнө. Тээвэрлэлтээс хөрсний бүтэц эвдрэх, газрын гадарга, хөрс ахуйн хаягдал шатахуун, тослох материалаар бохирдож болзошгүй.

Хүснэгт 11. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдал

| № | Нөлөөлөл                                                       | Нөлөөллийн эрчим цар хүрээ<br>Тохиолдох магадлал | Бага | Дунд | Их |
|---|----------------------------------------------------------------|--------------------------------------------------|------|------|----|
| 1 | Олборлолтын үйл ажиллагаанаас ландшафтын өөрчлөлт гарах        | Зайлшгүй                                         |      |      | х  |
|   |                                                                | Боломжтой                                        |      |      |    |
|   |                                                                | Магадлал муу                                     |      |      |    |
| 2 | Хөрсний морфологи шинж чанар алдагдах, эвдрэл талхлагдал үүсэх | Зайлшгүй                                         |      | х    |    |
|   |                                                                | Боломжтой                                        |      |      |    |
|   |                                                                | Магадлал муу                                     |      |      |    |

|         |                                                                             |                                                                                                                                                                                                                           |   |   |  |
|---------|-----------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---|--|
| 3       | Үржил шимт хөрсний нөөц багасах                                             | Зайлшгүй                                                                                                                                                                                                                  |   |   |  |
|         |                                                                             | Боломжтой                                                                                                                                                                                                                 |   | х |  |
|         |                                                                             | Магадлал муу                                                                                                                                                                                                              |   |   |  |
| 4       | Хөрсний овоолгоос шороо хийсэж орчныг бохирдуулах                           | Зайлшгүй                                                                                                                                                                                                                  |   | х |  |
|         |                                                                             | Боломжтой                                                                                                                                                                                                                 |   |   |  |
|         |                                                                             | Магадлал муу                                                                                                                                                                                                              |   |   |  |
| 5       | Хөрс ургамал талхлагдаж өнгөн хэсэг нь элсжих, нягтрах                      | Зайлшгүй                                                                                                                                                                                                                  |   |   |  |
|         |                                                                             | Боломжтой                                                                                                                                                                                                                 |   | х |  |
|         |                                                                             | Магадлал муу                                                                                                                                                                                                              |   |   |  |
| 6       | Хөрс-ургамалан бүрхэвчийн биологийн орчин муудах, шороонд дарагдах, ухагдах | Зайлшгүй                                                                                                                                                                                                                  |   |   |  |
|         |                                                                             | Боломжтой                                                                                                                                                                                                                 |   | х |  |
|         |                                                                             | Магадлал муу                                                                                                                                                                                                              |   |   |  |
| 7       | Хатуу болон шингэн хог хаягдлаар орчмын хөрсөн бүрхэвч бохирдох             | Зайлшгүй                                                                                                                                                                                                                  |   |   |  |
|         |                                                                             | Боломжтой                                                                                                                                                                                                                 | х |   |  |
|         |                                                                             | Магадлал муу                                                                                                                                                                                                              |   |   |  |
